

Төрийн албан хаагчийн ёс зүй

Н.Цолмонтуяа PhD, Дэд профессор

2018 он

АГУУЛГА

- Ёс зүй, ёс суртахууны тухай ойлголт
- Төрийн албаны зарчим, үнэт зүйлс
- Төрийн албан хаагчийн ёс зүйн ХЭМ, ХЭМЖЭЭ

Mahatma Gandhi Seven things will destroy us

Хүн төрлөхтнийг эвддэг 7 зүйл

- **Wealth Without Work** Хөдөлмөрлөж хөлсөө дуслуулаагүй баялаг
- **Pleasure Without Conscience** Ухамсаргүй зугаа цэнгэл
- **Knowledge without Character** Зан суртахуунгүй мэдлэг
- **Commerce (Business) Without Morality (Ethics)** Ёс суртахуунгүй бизнес
- **Science Without Humanity** Хүмүүнлэг бус шинжлэх ухаан
- **Religion Without Sacrifice** Итгэл үнэмшилгүй шашин
- **Politics Without Principle** Зарчимгүй улс төр

2017 онд НҮБ “Тогтвортой хөгжлийн шийдэл” Аз жаргалын индекс

- **Нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүн,**
- **Нийгмийн халамжын бодлого,**
- **Эрүүл амьдрах дундаж наслалт,**
- **Өөртөө хэрэгтэй сонголт хийх эрх чөлөө,**
- **Өгөөмөр байдал**
- **Авлига, хээл хахууль**

Аз жаргалын индекс Тэргүүлж буй улс орнууд 2016

Norway	7.537
Denmark	7.522
Iceland	7.504
Switzerland	7.494
Finland	7.469
Netherlands	7.377
Canada	7.316
New Zealand	7.314
Australia	7.284
Sweden	7.284
Israel	7.213
Mongolia	4.955

World's happiest country Netherlands 2017



Энэхүү судалгаагаар 2017 онд Нидерланд тэргүүлж Норвеги, Дани, Исланд, Швейцар, Финланд зэрэг орнууд удаалсан байна.

Монгол Улс 4.907 оноогоор 157 орноос 100-д орсон байна. Харин ОХУ 49, Япон 51, Казахстан 60, БНСУ 55, БНХАУ 79-р байр эзэлсэн байна.



Emen	3.593
South Sudan	3.591
Liberia	3.533
Guinea	3.507
Togo	3.495
Rwanda	3.471
Syria	3.462
Tanzania	3.349
Burundi	2.905
Central African Republic	2.693

Ёс зүй, ёс суртахууны тухай ойлголт

1. Ёс зүй бол үнэт зүйлс мөн.

- Гүн ухааны зарим, ном, бүтээлд үнэлэмж
- Төрийн албанд эрхэмлэн дээдлэх зүйлс

2. Германы социологч М. Вебер ёс зүйг:

- Итгэл үнэмшлийн
- Хариуцлагын гэж 2 ангилсан

3. Зарим судлаачид ёс зүйг үүргийн тухай шинжлэх ухаан гэж үздэг /Деонтолог/

4. Ёс зүй хэмээх ойлголт нь хууль эрх зүй хэмээх ойлголтоос өргөн хүрээтэй бичигдээгүй хууль буюу зан заншил, уламжлал, соёл хэлбэрээр оршин тогтнож ирсэн онцлогтой. Харин орчин үед төрийн албанд хууль, дүрэм журмаар зохицуулж байна. Жишээ нь: 2012 онд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль батлагдсан.

Төрийн албан хаагчийн ёс зүй

Төрийн захиргааны албан хаагчийн албан тушаалын бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд баримталбал зохих үнэт зүйлс, зарчим, хэм хэмжээ, зан үйлийн нийлбэр цогц.

Төрийн албаны үндсэн зарчим


Монгол Улсын Үндсэн хуулийн 1-р зүйлийн 2 дахь хэсэгт төрийн албаны үндсэн зарчмыг **ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх** хэмээн тодорхойлсон байна.

Төрийн албаны үнэт зүйлс

- **Шударга байх (honesty)**
- Энэ нь нийгмийн бүх хүрээнд эрхэмлэх суурь чанар боловч төрийн албан хаагчдын хувьд нийтийн итгэлийг даах чадвар, нийтийн ашиг сонирхлыг хувийн ашиг сонирхлоос дээгүүр тавих гэсэн утга агуулдаг
- **Алагчлалгүй, зарчимч байх (impartiality)**
- Энэ нь үндэс угсаа, шашин шүтлэг, хүйс эсвэл эдийн засгийн байдлаар үл ялгаварлан гадуурхахын зэрэгцээ улс төрийн хувьд төвийг сахисан, нам бус байхыг ойлгодог.
- **Үнэнч байх (loyalty)**
- Ардчилсан тогтолцоонд улс төрийн удирдлагад үнэнч байх нь төрийн албан хаагчийн үүрэг боловч энэ нь ёс зүйгүй зан байдал гаргах тохиолдлоор хязгаарлагддаг.
- Төрийн албан хаагчын хувьд засгийн газарт болон хэрэглэгчдэд үйлчлэх үүргийн хооронд зөрчил гарах учиргүй. Гэвч практикт төрийн албан хаагчид иргэдэд үйлчлэх, хариуцлагатай ажиллахын тулд өдөр тутам бие дааж шийдвэр гаргах хэрэгтэй болдог бөгөөд энэ нь тэдний удирдлагадаа үнэнч байдалтай зөрчилдөх тохиолдол гарч болдог.

- **Тасралтгүй, залгамж чанар (continuity)**
- Төрийн албан хаагчид иргэдэд тогтвортой, тасралтгүй үйлчилгээ хүргэх үүрэгтэй. Тасралтгүй байх гэдэг нь ажлын байрыг эзэнгүйдүүлэхгүй байх, төрийн албан тушаалтай харшлахгүй хязгаарлагдмал тохиолдолд л бусад мэргэжлийн үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрөх гэсэн утга агуулдаг. Тасралтгүй ажиллагааны өөр нэг асуудал нь төрийн албан хаагчдад ажлаас чөлөөлөгдөхдөө албан хэрэгтэй холбоотой аливаа мэдээллийг нуун дарагдуулах, эсвэл устгахыг хориглодог.
- **Ил тод байдал ба бие дааж шийдвэр гаргах эрх мэдлийг тэнцвэржүүлэх (balancing transparency and discretion).**
- Нээлттэй байдал нэмэгдсэнээр иргэд, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл өргөн хяналт тавих боломжтой болдог. Иймд нээлттэй байх үүрэг ба бие дааж шийдвэр гаргах эрх мэдэл тэнцвэртэй байх хэрэгтэй. Энэ нь төрийн албан хаагчдын ямар мэдээллийг, хэнд гаргаж өгөх эрхийг тодорхойлсон тодорхой журам шаардлагатай гэсэн үг юм.
- **Хариуцлага ба хариуцан тайлагнах (responsibility and accountability)**
- Төрийн албан хаагчид гаргасан шийдвэр, үйл ажиллагааныхаа төлөө хариуцлага хүлээх чадвартай, тайлагнадаг байхыг төрийн албанд баримтлах нийтлэг үнэт зүйлсийн хэмжээнд авч үзэж байна.

Төрийн албанд суурь үнэт зүйлсийг тодорхойлсон улс орнууд



Эх сурвалж: *Ethical measures in OECD countries: Trust in government, 2000*,
р. 32

ЭЗХХАХБ-ын гишүүн улс орнуудын хувьд зарчимч тууштай байх зарчмыг 24 улс орон, хууль дээдлэх зарчмыг 22, шударга ёсны зарчмыг 18, ил тод, тунгалаг байх зарчмыг 14, төрийн байгууллагууд үр ашигтай байх зарчмыг 14, улс тэгш байдлыг 11 улс, хариуцлагатай байх зарчмыг 11, шударга ёсны зарчмыг 10 улс орон тус тус хүлээн зөвшөөрч, эрх зүйн хувьд баталгаажуулсан байна.

Төрийн захиргааны албан хаагчийн эрхэмлэн дээдлэх зүйлс

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ХААГЧИЙН ЕС ЗҮЙН ДҮРЭМ

ЗГ-ын 2010 оны 288 дугаар тогтоолоор батлагдсан

шударга ёсны зарчмын хүрээнд: хүлээсэн үүрэгтээ үнэнч байж, нийтийн ашиг сонирхолд захирагдан ашиг сонирхлын зөрчилд автахгүй байх, хууль бус, шударга бус явдалтай эвлэршгүй байж, бусдыг манлайлах;

- **хууль дээдлэх зарчмын хүрээнд:** төрийн бодлого, шийдвэрийг боловсруулах болон төрийн албаны бүхий л үйл ажиллагаанд Үндсэн хууль, бусад хуулийг ямагт дээдлэн сахих;
- **тэгш байдлын зарчмын хүрээнд:** бусад төрийн албан хаагч болон үйлчлүүлэгч, иргэн бүртэй адил тэгш, алагчлалгүй харьцан байгууллагын хөгжилд өөрийн хувь нэмрийг оруулах;
- **хариуцлага хүлээх зарчмын хүрээнд:** албан үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай өөрийн мэдлэг чадварыг байнга дээшлүүлж, хийсэн ажлынхаа гүйцэтгэл, үр дүнгийн төлөө бүрэн хариуцлага хүлээх;
- **олон нийтэд үйлчлэх зарчмын хүрээнд:** төрийн үйлчилгээг олон нийтэд чанартай, хүртээмжтэй, шуурхай, соёлтой хүргэж, тэдний итгэлийг хүлээж ажиллах.

*Анхаарал хандуулсанд
баярлалаа*

